

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААД ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд, гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуульд заасан төслийн гадаад зээлийн эх үүсвэрийг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулсан эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

2.1. Энэ хуулийн үйлчлэлд гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх доор дурдсан төсөл хамаарна:

2.1.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл;

2.1.2. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл.

2.2. Энэ хуулийн 2.1-д заасан төслийн нэрийг өөрчлөх, шинэ төсөл нэмэхийг хориглоно.

2.3. Энэ хуулийн 2.1-д заасан гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГАДААД ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, НЭГДСЭН ТӨСӨВ ХООРОНДЫН ХАМААРАЛ

3 дугаар зүйл. Гадаад зээлийн ашиглалтын зардал

3.1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн тухайн жилийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болох бөгөөд нэмэгдсэн дүн нь дээрх хязгаарт хамаарахгүй.

3.2. Тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан гадаад зээл, тусламжаас санхүүжүүлэх зардал энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ

4 дүгээр зүйл. Гадаад зээлийн ашиглалтын ил тод байдал, хяналт

4.1. Засгийн газар энэ хуулийн хэрэгжилтийн талаарх тайланг тухайн жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хамт Улсын Их Хуралд хүргүүлнэ.

4.2. Энэ хуулийн 2.1-д заасан төслийн хэрэгжилт, санхүүжилт, гадаад зээлийн ашиглалттай холбоотой мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олон нийтэд ил тод, нээлттэй, тогтмол мэдээлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

5 дугаар зүйл. Хууийг дагаж мөрдөх журам

5.1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар баталсан гадаад зээл, тусламжаас санхүүжих зардлаас энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалтад санхүүжүүлсэн зардлыг энэ хуулийн 3.1, 3.2-т заасан үйлчлэлд хамруулна.

5.2. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10.2-т заасан Засгийн газрын авч ашиглах гадаад зээлийн дээд хэмжээ нь энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

5.3. Энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалт бүрэн дуусах хүртэлх хугацаанд энэ хуулийг дагаж мөрдөнө.

Гарын үсэг